


БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСАД АЖИЛЛАХ
ҮЕЭР БАРИМТЛАХ УДИРДАМЖ

Сангийн сайд Б.Жавхлан 2022 оны 2 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын Вашингтон хотноо ажиллах үеэр Олон улсын валютын сан болон Дэлхийн банкны удирдлагатай уулзахдаа дараахь чиглэлийг удирдамж болгон ажиллана. Үүнд:

Нэг. Үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэл:

- Сангийн сайд Б.Жавхлан Олон улсын валютын сан болон Дэлхийн банкны удирдлагуудтай дараахь сэдвээр мэдээлэл өгч, санал солилцоно:
 - Монгол Улс дахь КОВИД-19 цар тахлын халдварын нөхцөл байдал, цар тахлын эсрэг Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өгөх;
 - Монгол Улсын өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, Засгийн газраас явуулж буй бодлого, төсөв, нийгмийн салбарт хийж буй шинэчлэлийн асуудлаар мэдээлэл өгөх;
 - Монгол Улс, Олон улсын валютын сан (ОУВС) хоорондын болон Монгол Улс, Дэлхийн банкны групп хоорондын 30 жилийн хамтын ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, санал солилцох;
 - Монгол Улс Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлэхээр яригдаж буй төсвийн дэмжлэг буюу бодлогын зээлийн хөтөлбөр болон бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар санал солилцох;
 - Монгол Улс болон ОУВС хооронд санхүүгийн хамтын ажиллагааны боломжит хувилбарууд болон хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, техник туслалцааны талаар санал солилцох.

Хоёр. Хоёр талын уулзалт хийх:

- Олон улсын валютын сангийн Дэд гүйцэтгэх захирал ноён Кенжи Окамура,
- Олон улсын валютын сангийн Ази, Номхон далайн газрын захирал ноён Чанг Ёнг Ри,
- Олон улсын валютын сангийн Монгол Улсыг хариуцсан ажлын хэсгийн ахлагч хатагтай Ангана Банержи, ажлын хэсгийн гишүүд,
- Дэлхийн банкны Ази, Номхон далайн Бүс нутгийг хариуцсан Дэд ерөнхийлөгч хатагтай Мануэло Ферро,
- Дэлхийн банканд Монгол Улсыг төлөөлдөг Бүс нутгийн гүйцэтгэх захирал ноён Найжел Рэй.